

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТЭСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ДАШДОРЖИЙН БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг судалж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг боловсруулах, зохицуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлагнах;							
1	ЗГҮАХ 2.1.7.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний батлагдсан загварын дагуу хувийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлнэ (ГТ-1.1.19)	Урт хугацааны тусламж, үйлчилгээнд улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлсэн хэмжээ	10%	100%	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/511 дүгээр тушаалаар “Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар” боловсруулах ажлын хэсгийг байгуулж, загварын хувилбаруудын төслийг боловсруулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ч дахин боловсруулалт хийх шийдвэр гарсан. Хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, тусламж, үйлчилгээний нэр төрлийн шинэ заалтууд оруулахаар 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1678 дугаар албан бичгээр саналаа хууль санаачлагчид хүргүүлсэн. Урт хугацааны тусламж, үйлчилгээг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан оношийн хамааралтай бүлгийн	2024.01.01-2024.12.31	100%

101

					жагсаалтад дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээний 12 оношийн хамааралтай бүлэг үүсгэсэн бол 2024 оны 06 тогтоолоор 9 ОХБ болгож бууруулсан байна. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сонгон шалгаруулалтын үндсэн дээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулж, иргэн даатгуулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг шинэчлэж, 2024.03.29-ны өдөр “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаартай тогтоолыг баталсантай холбогдуулан Дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээний амбулаторийн үзлэг 20,800 төгрөг, өдрийн эмчилгээ 223.600-410.800 төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ нь 812.600-1.300.000 төгрөгөөр ЭМДС-аас санхүүжиж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас Дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээнд 11.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна., үйлчилгээнд 8,3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.		
2	ЗГҮАХ-2.1.13.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ (ГТ-1.1.21).	Гүйцэтгэлийн санхүүжилт нэвтэрсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тоо, тусламж үйлчилгээний багцын тоо, олгосон санхүүжилт	50%	20%	Анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор 2022 онд Эрүүл мэндийн даатгалийн сангийн төсвийн тухай хуулийг батлахдаа УИХ-аас чиглэл болгож нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд 2023 онд ЭМД санхүүжилтийн 22.1 хувийг Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулсан бол 2024 онд 23.5 хувийг зарцуулахаар төлөвлөж, зардлыг 1.4 хувиар өсгөсөн байна. Мөн ЭМДСангийн төсвийн нарийвчилсан хуваариар Анхан шатны тусламж, үйлчилгээнд 2024 онд нийт 455.1 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан бөгөөд 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 267.2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.	2024.01.01-2024.12.31	100%

ed

					Анхны шатны тусламж, үйлчилгээгээр 2024.01.01-ны өдрөөс нийт 546 эрүүл мэндийн байгууллага гэрээ байгуулснаас 328 нь сум, тосгоны эрүүл мэндийн төв, 218 нь өрхийн эрүүл мэндийн төв байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, МУ ЗГ-ын 2023.06.21-ны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол 2024.04.01-нээс хэрэгжихтэй холбоотойгоор 2023 онд батлагдсан 06 тогтоолыг 2024.03.29-ны өдрийн ЭМДҮЗ-ийн 05 дугаартай тогтоолоор шинэчилэн баталж, 2024.04.01-ны өдрөөс мөрдөн ажиллаж байна. Уг тогтоолоор Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээгээр 154 нэр төрлийн тусламж, үйлчилгээ 150 багц батлагдсан.		
3	ЗГҮАХ 2.1.7.5. Эрүүл мэндийн даатгалын эрсдлийн сан байгуулна.(ГТ-1.1.18)	Эрсдлийн сангийн хэмжээ /53,562.0/	10%	100%	ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар Эрсдэлийн санг 53,6 тэрбум төгрөг буюу нийт төсвийн 2,8%-иар ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж ажилласан ба 2025 төсвийн төсөлд нийт 2025 оны төсвийн 5 хувьд хүргэх буюу 124.7 тэрбум төгрөгт хүргэх саналыг УИХ-д төсвийн хамт хүргүүлээд байна.	2024.01.01-2024.12.31	100%
4	Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих журмын төслийг боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг хангана. /140 дугаар/	Батлагдсан журмын огноо, дугаар	30%	30%	Гүйцэтгэлийн санхүүжилтийн зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих журмын төслийг боловсруулж, газрын даргад танилцуулсан. Журам нь 10 хэсэг, 2 хавсралтаас бүрдэх бөгөөд төсвийн төлөвлөлт, хуваарь, зарцуулалтын эрх нээх, санхүүгийн тайлагналт, мөнгөн тэтгэмж олгох, төрийн сангийн зардлын гүйлгээ гаргах, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэх, зохицуулалт болон урамшуулал олгох зэргийг уг журмаар зохицуулахаар боловсруулагдсан байна.	2024.01.01-2024.12.31	30%
5	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн	Төсөвлөсөн санхүүжилтийн дүн	0%	100%	2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийн саналыг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг сайжруулах, Эрүүл мэндийн	2024.01.01-2024.12.31	100%

	төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг холбогдох эрхзүйн хүрээнд нэгтгэж, санал өгнө. /115 дугаар/				даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Төсвийн удирдамж хүргүүлэх тухай" 01/5374 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу боловсруулж Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны төсвийн төслийг олон нийтэд ил тодоор мэдээлж цахим хэлбэрээр санал асуулга авч Сангийн яаманд 2024.08.19 2/3401 дүгээр албан бичгээр хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн хүргүүлсэн ба 2024.09.26-ны өдөр Засгийн газрын ордонд нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, Сангийн яам болон олон нийтийн төлөөллийг байлцуулан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.		
6	Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн статусыг тодорхой болгож, ЭМЯ-ны хөрөнгөд бүртгэлтэй байгаа барилга, газрыг байгууллагад шилжүүлж өгнө.	Судалгааны тоо	0%	100%	Эрүүл мэндийн яамны ТНБД-ын 2024 оны А/43 тушаалаар МСДАУТ-д ажлын хэсэг байгуулагдаж, 2024.04.22-ны өдөр ажлын хэсэг ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, өмч хөрөнгийн талаар болон хүний нөөц, санхүүжилтийн талаархи мэдээллийг авч, хянасан. Үр дүнд МСДАУТ нь 2004 оноос үйл ажиллагаа явуулж, өөрийн санхүүжилтээр бие дан ажилласан бөгөөд Оргил рашаан сувилалд сүүлийн 10 жилийн байдлаар газрын төлбөрт 181.5 сая төгрөгийг тушаасан байна. Гэвч МУЗГ болон БНСУ-ын буцалтгүй тусламжаар Оргил рашаан сувилалыг түшиглэн байгуулсан уг төв Оргил рашаан сувилаллыг хувьчилсантай холбоотойгоор өмчийн маргаан үүсэж эхэлсэн байна. Иймд ажлын хэсэг тайландаа холбогдох дүгнэлтийг хавсаргаж цаашид авч хэрэгжүүлэх 4 саналтайгаар ТНБД-д тайланг танилцуулсан. Үүнд: - Тус төвийн статус, хариуцлагын хэлбэр, харьяалал, удирдлага эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох. - ЭМЯ харьяа тул Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.1-т заасны дагуу төрийн байгууллагын	2024.01.01-2024.12.31	100%

100%

					болон албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнг холбогдох журмын дагуу байгуулж, үнэлж дүгнэх. - Тус төвөөс эмчилгээнд ашиглагдаж буй эмэнд холбогдох хууль, дүрэм журмын дагуу чанар аюулгүй байдлыг хангуулах. - БНСУ болон МУЗГ-аас хамтран ажиллах хүрээнд МУЗГ-ын үүрэгт газрыг шийдвэрлэж, Оргил рашаан сувилалын 10 өрөөг олгосон байдаг. Иймд хэрэгжилтийг хангуулж, ТӨБЗГ-т уламжилж, асуудлыг шийдвэрлүүлэх.		
7	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлууна.(ГТ-1.1.17)	Нэмэлт өөрчлөлт оруулахаар өгсөн саналын тоо	0%	0%	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулагдаагүй.	2024.01.01-2024.12.31	0%
8	ЗГҮАХ 2.1.7.2. Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгуулллагад Улсын төсөв /ЭМДС/-аас амбулатори, өдрийн эмчилгээ оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана.	Гэрээ байгуулсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь /90%-д/	0%	100%	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтад тэнцсэн 196 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай 3 жил буюу 2022-2025 оны хугацаатай даатгалын гэрээг 2022 оны 09 дүгээр сард байгуулсан. Улсын хэмжээнд 215 ортой хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас үүний 193 нь гэрээ байгуулсан нь 89.8% эзэлж байна. Улсын хэмжээнд 1,458 оргүй хувийн эмнэлэг клиник хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа үүний зөвхөн 5 эмнэлэгтэй гэрээ байгуулж, энэ нь 0.34 хувийг эзэлж байна. Клиник хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа 1,458 хувийн эмнэлэг байгаа бөгөөд цаашид магадлан итгэмжлэлд хамрагдаж, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах эрх үүсэх юм. Улсын хэмжээнд хувийн хэвшлийн 1,673 оргүй болон ортой хувийн хэвшлийн эмнэлэг үйл	2024.01.01-2024.12.31	100%

					ажиллагаа явуулж байгаагаас 196 нь Эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулсан нь 11.7 хувийг эзэлж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар 244.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.		
9	Эрүүл мэндийн даатгалын санд үйлчилгээ үзүүлэгчдээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг барагдуулсан хугацааны тайланг ЭМДЕГ-аас улирал бүр авч, хоцорсон шалтгаан нөхцлийг тогтоон, нэхэмжлэлийг тухай бүрт барагдуулах тал дээр хамтран ажиллана.	Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт хийгдсэн байна.	0%	100%	2024 оны 11 дүгээр сарын байдлаар ЭМД сангаас 1.623.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 19.3 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт хийгдэж 1.715.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн олгоод байна. Үүнээс харахад - Эмийн үнийн хөнгөлөлт, новартис болон төр хариуцах эмийн санхүүжилтэд 114.5 тэрбум төгрөг - Нэг иргэнд ногдох норматив зардал – 276.6 тэрбум төгрөг. - Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт 31.8 тэрбум төгрөг. - Эрүүл мэндий өайгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд - 1.200.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, санхүүжилтийг олгоод байна. Мөн 2024 оны жилийн эцэс болж буйтай холбогдуулан ЭМДЕГ-т 2024.10.17-ны а/4243 дугаартай албан бичгээр дараах чиглэлийг хүргүүлсэн. Үүнд - Нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээг хязгаарлах - 2024 оны Эрсдлийн санг өглөгийг бууруулах зорилгоор журмын дагуу ЭМДҮЗ-ээр хэлэлцүүлэх - Гэрээгээр үзүүлж буй тусламж, үйлчилгээний тоо хэмжээ хэтэрсэн тохиолдолд гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.	2024.01.01-2024.12.31	100% 80%
10	Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2024 оны төсвийн жилд өр төлбөр	Өр төлбөргүй гарсан байна.	0%	50%	2024.04.25-ны 1а/1721 тоот албан бичгээр Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарт Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог эрчимжүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлыг	2024.01.01-2024.12.31	100% 80%

2024.04.25-ны 1а/1721 тоот албан бичгээр Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарт Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог эрчимжүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлыг

	үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авч, ажиллана.				шийдвэрлэхэд онцгой анхаарах ажлын хүрээнд 4 чиглэл бүхий албан бичгийг Эрүүл мэндийн сайдаас хүргүүлсэн. Мөн 2024.05.29-ны 07/2287 дугаартай албан бичгээр Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газарт авлага үүссэн, санхүүжилтээ шийдвэрлүүлж чадаагүй гэх 7 эмнэлгийн асуудлыг уламжилж, хариу арга хэмжээ авахыг үүрэг болгосон. 2023 оны жилийн эцсийн байдлаар эмнэлгүүдэд 218 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангаас сар бүр тодорхой түвшинд буулгахаар ажиллаж, 2024 байдлаар 69 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, нийт өр төлбөрийн 70 хувийг барагдуулаад байна.		
11	Төлбөрийн чадваргүй болсны улмаас албадан татан буугдсан "Капитал банк"-д байршиж байсан Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх чиглэлээр хамтран ажиллана.	Капитал банкны авлага 78.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.	0%	100%	Капитал банкнаас 136.1 тэрбум төгрөгийн авлагаас 2024 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар тус банкны эрх хүлээн авагч 13.3 тэрбум төгрөг бэлэн мөнгөөр төлсөн. Мөн 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө хүлээн авч үүнээс 10.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч, Капитал банкны авлага 76.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөөс нийт 32 аж ахуй нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд: Улаанбаатар хотод 20, Говь-Алтай 2, Говь-Сүмбэрт 10 аж ахуйн нэгж, хувь хүнтэй түрээсийн гэрээ байгуулж, 2024 оны 11 дугаар сарын 30-ний байдлаар 844,8 сая төгрөгийн түрээсийн орлогыг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээд байна.	2024.01.01-2024.12.31	100%
12	Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төрд хураагдсан барилгыг эрүүл мэндийн салбарт эмнэлгийн зориулалтаар	Санал өгсөн байна.	0%	0%	Санал ирээгүй.	2024.01.01-2024.12.31	0%

	ашиглах, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд санал өгнө.						
13	Эрүүл мэндийн даатгалаар олгогддог хөнгөлөлттэй эмийн чанарыг сайжруулах, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулан иргэдэд хүндрэлгүй байдлаар зохион байгуулах арга хэмжээ авч ажиллана.	Хөнгөлөлттэй эмийн журамд санал өгнө.	0%	0%	Санал ирээгүй.	2024.01.01-2024.12.31	0%

Зорилт 2. “Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх”

1.	Харьяалах газар, хэлтсийн даргаас шилжүүлсэн албан бичиг, өргөдлийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлнэ.	Шийдвэрлэсэн албан бичиг өргөдөл	0%	100%	Тайлант хугацаанд нийт 140 албан бичиг ирсэн бөгөөд 147 албан бичгийг хааж, иргэдээс ирүүлсэн 18 өргөдөл гомдолд хариу өгч ажилласан. 3 албан бичиг хяналтын шатанд байна. Мөн харьяалах газар, хэлтсээс ирүүлсэн санал авах 18 хууль, дүрэм, журам, тогтоолын төсөлд хариу хүргүүлсэн.	2024.01.01-2024.12.31	100%
2.	Өөрийн хариуцсан албан тушаалын хүрээнд архив, албан	Архивт хүлээлгэн өгсөн баримт	0%	100%	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд орсон санхүүгийн аудитад баримт бичиг өгөх, архивт хүлээлгэн	2024.01.01-2024.12.31	100%

32

	хэрэг хөтлөлтийн стандартын дагуу бүрдүүлж хүлээлгэн өгөх.				өгөх ажлын хүрээнд санхүү, хөрөнгө оруулалтын 20 баримтыг үдэж, дугаарлан, хүлээлгэн өгөв.		
3.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан байна	0%	100%	2024 оны Гүйцэтгэлийн санхүүжилтийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. Үүнд Зорилт 1 – 13 ажил Зорилт 2 – 5 ажил хийхээр тус тус төлөвлөсөн байна.	2024.01.01- 2024.12.31	100%
4.	2024 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	0%	100%	2024 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 20-ны дотор гаргаж, ТЗУГ-т хүргүүлсэн.	2024.01.01- 2024.12.31	100%
5.	Газар, хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, шаардлагатай тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Үүрэг даалгавар, мэдээллийн тоо	0%	100%	Газрын даргаас өгсөн дараах чиг үүргийн дагуу мэдээллийг гаргаж, холбогдох газар, хэлтэст хүргүүлэн ажилласан. Үүнд: 1- Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдах ажилтны зөвлөгөөнд Анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэсэн. 2- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Процессын дахин инженерчлэлийн хүрээнд холбогдох санхүүгийн мэдээллийг гаргаж хүргүүлсэн. 3- ПДИ-ийн санхүүгийн судалгааны багт орж, Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл тусламжаар 2013-2023 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтад Үнэлгээ, судалгаа хийж, Засгийн газрын хяналтхэрэгжүүлэх газарт судалгааг хүлээлгэн өгсөн.	2024.01.01- 2024.12.31	100%

					ТЗУГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хоног бүрийн ажлыг төлөвлөж, төлөвлөгөөг гаргасан. 5- СДХ-ийн хийсэн 2024 оны хагас жилийн тайлангийн танилцуулгыг бэлтгэж, удирдлагад танилцуулав. 6- Д вирустай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлын тооцооллыг хийж, ажлын хэсэгт ажиллав. 7- Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн хүрээнд ажлын хэсэгт орж, холбогдох мэдээллийг өгч ажилласан. 8- Хавдрын Үндэсний багт орж, 6 төрлийн голлох хавдрын ТҮ-ний 118 хөтөлбөр, үүн дотроо сургалтын 33 хөтөлбөрт суурь төсөв тооцож, 6 хавдрын ТҮ-ний багц тодорхойлох суурь судалгааг хийж, удирдлагын баг болон сайдад танилцуулсан. 9- Эрүүл мэндийн салбарын 2025 оны төсөв, 2026-2027 оны төсвийн төсөөллийн эрүүл мэндийн даатгалын сан тал дээр хяналт хийж, нэгтгэн, холбогдох танилцуулгыг бэлтгэж, сангийн яаманд хүргүүлэв.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл- тийн хувь
1.	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан Процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгт орж ажиллах	Мэдээлэл цуглуулж, тайлагнасан байна.	Ажлын хэсэгт орох	Ажлын хэсэгт тайлагн асан байна.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгт орж, чиг үүргийн дагуу үндсэн баг болон санхүүгийн шинжилгээний багуудад хувиарлагдан ажиллалаа. Үүнд 1 - МУ-ын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2024.05.06-ны 1/388 дугаартай албан бичгээр ЭМЯ-аас албан бичиг ирүүлсн бөгөөд "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу 2024.03.18-2024.04.19-ны хооронд	2024.01.01 - 2024.12.31	100%

100

					ажилласан. Уг хугацаанд ЭМДЕГ-т мэдээлэл цуглуулахаар ажлын хэсэгт ажиллаж, тус байгууллагын үйл ажиллагааны процессын зураглал, фокус ярилцлага хийж, үр дүнг ажлын хэсэгт танилцуулан ажилласан. Улмаар 2024.05.10-нд Үр дүнгийн хурал хийж, ажлын тайланг танилцуулсан. 2 Мөн Санхүүгийн шинжилгээний ажлын хэсэгт орж 2024.05.01-ны өдрийг хүртэл 2 удаагийн санхүүгийн тайлан, Гадны зээл тусламжаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтуудын төслүүдэд дүн шинжилгээ хийж хүргүүлсэн.		
2.	2023 оны үйл ажиллагааны тайлантай холбоотой мэдээллийг гаргаж хүргүүлэх.		Ажлын хэсэгт орох	Ажлын хэсэгт тайлагн асан байна.	1- Үндэсний аудитын газарт “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн тайлангийн шаардлага зөвлөмжийн биелэлтийг 2024.02.29-ны 2/873 дугаартай албан бичгээр МУ-ын Ерөнхий аудитор Д.Загджавт хүргүүлсэн. 2- Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитыг газарт Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, үр дүнд хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой 08/1055 пугаартай албан бичгийн дагуу 2024.05.09-ны 2/1981 дугаартай хариу албан бичгээр нэмэлт нотлох баримтуудыг хүргүүлэн ажилласан.	2024.01.01 - 2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан чиглэлийн	Суралцсан кредит цаг	0	1 кредит цаг	Эрүүл мэндийн яамнаас албан хаагч нартаа зориулан зохион байгуулсан цахим болон танхимын сургалтуудад амжилттай хамрагдсан. 1. Төрийн албаны шинэтгэл ба “Цэгцрэх хөдөлгөөн” сэдвээр УИХ-ын дарга Г.Занданшатар;	2024.01.01 - 2024.12.31	100%

МН

	сургалтад хамрагдана.				2. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа" сэдвээр УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа. 3. бүтээмжийн сэргэлт-цахим эрүүл мэнд" 4. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг сургалт. 5. Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооноос Монгол Улсын төрийн соёрхолт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич С.Нарангэрэл хуульчийн сургалт. 6. "БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА" сэдвээр Монгол Улсын Их сургуулийн зөвлөх багш доктор, профессор Л.Оюун. 7. Процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгт Сэтгэл судлал, хүний нөөцийн удирдлагын сургалт. 8. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Цагдаагийн Ерөнхий газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газруудаас зохион байгуулсан танхимын сургалтад тус тус амжилттай хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 2. Мэргэжлийн чадварийг дээшлүүлж, Нийгмийн ухаан докторын танхимын сургалтанд сурна.	Суралцсан кредит цаг	0	8 кредит цаг	1 – Удирдлагын академиас зохион байгуулсан "Багшлах эрх олгох" 12 кредит цагийн сургалтад сууж, Боловсролын их сургуулийн ректор У.Батбаатарын 2024.06.04-ны А/240 тушаалаар "Багшлах эрх"-тэй болсон. 2- Удирдлагын академийн Төрийн удирдлагын докторын ангийн Хавар болон намрын цугларалтад суралцаж, 16 кредит цаг цуглуулж, докторантын танхимын хичээлээ дүүргэсэн.	2024.01.01 - 2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэлийн санхүүжилтийн төлөвлөлт,
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

.....
Д.Баярмаа
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

211